

**ХКН-ЫН XVШ ИХ ХУРАЛ БОЛОН ХЯТАДЫН
НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН
ТАЛААРХ ОРОСЫН ЭРДЭМТЭН,
СУДЛААЧДЫН БАЙР СУУРЬ**

Ч.Батцэцэг*

Товч утга:

ХКН-ын XVШ их хурлын үйл явц, онцлог, ач холбогдол, “тав дахь үеийн” шинэ удирдлага, Хятадын нийгэм-эдийн засгийн хөгжлийн асуудлаар гадаадын хэвлэл, мэдээллийн хэрэгслэлээр нийтлэгдсэн материал, Оросын эрдэмтэн, судлаачдын байр суурь, үзэл бодлыг авч үзлээ.

Түлхүүр үгс: ХКН, их хурал, шинэ удирдлага, улс төр, эдийн засаг, нийгмийн хөгжил

2012 оны 11 дүгээр сарын 8-14-ний хооронд хуралдсан ХКН-ын XVШ их хурал нь арав дахь жилдээ төр, засаг барьж буй удирдлагаа шинэчлэх улмаар энэхүү шинээр сонгогдсон тав дахь үеийн удирдлага Хятадын хөгжлийн ирэх 10 жилийн төлөв байдлыг тодорхойлж, эдийн засгийн хөгжлийн арга хэлбэрийг шинэчилж, өөрчлөлтийг түргэсгэх зорилтыг хэрэгжүүлэх болно. Иймээс дэлхий нийтийн анхаарлын төвд байж, хэвлэл мэдээллийн хэрэгслэлүүд өөр өөрийн сувгаар, өөр өөрийнхөө өнцгөөс мэдээлж, гадаадын эрдэмтэн судлаачид Хятадад болж буй үйл явдлын талаар дүгнэлт хийж, санаа бодлоо илэрхийлсээр байна.

БНХАУ-ыг 1949 оны аравдугаар сарын 1-нд тунхагласнаас хойшхи тав дахь үеийн удирдлагыг ХКН-ын 82 сая гишүүнийг төлөөлсөн 2325 төлөөлөгч энэ их хурлаас тодруулсан юм. Хятадын төр, засгийн удирдлагад хэн хэн байхыг их хурлын өмнө хуралдсан ХКН-ын Төв Хорооны долдугаар бүгд хурлаар үндсэндээ нэрлээд байв. Их хурлаар хэлэлцэн тогтоод 2013 оны гуравдугаар сард Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлаар /БХАТИХ/ шинэ удирдлагад бүрэн эрхийг нь олгож батламжилжээ. Юуны өмнө ХКН-ын Төв Хорооны Байнгын хорооны 9 гишүүний орон тоог

*Ч.Батцэцэг - Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

7 болгон цөөлсөн байна. Байнгын хорооны бүрэлдэхүүнд ХКН доторхи бүлэглэлүүдээс “хувь тэнцүү” оруулахаар болсныг өөрчлөлт шинэчлэлийн шинж хэмээн гадны ажиглагчид харж байлаа. Хятадын тав дахь үеийн удирдагчдын бүрэлдэхүүнд БНХАУ-ын дэд дарга Си Зиньпин, Төрийн зөвлөлийн Ерөнхий сайдын орлогч Ли Кэцян, Ерөнхий сайдын санхүү эрхэлсэн орлогч Ван Цишань, Намын дээд удирдлагын төлөөлөл болох Лю Юньшань, Ли Юаньчао, Жан Дэцян, Жан Гаоли нар оров. Тэднээс Си Зиньпин улсаа даргалж, Ли Кэцян Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд болох нь тодорхой боллоо хэмээн Agence France Press /AFP/ мэдээлж байсан юм.

Шинэ удирдлагын нэрсийн жагсаалтыг БНХАУ-ын дарга Ху Зиньтао, түүний залгамжлагч хэмээгдэж буй БНХАУ-ын дэд дарга Си Зиньпин, Хятадын гурав дахь үеийн тэргүүн Зян Зэминь нар батламжилсан байна. БХАТИХ-ын 12 дугаар чуулган дээр Си Зиньпиний нэрийг нууцаар сонгожээ. Бүх төлөөлөгчдийн саналыг тоолсны дараа бараг 3000 төлөөлөгчөөс нэг хүн татгалзаж, гурван хүн түдгэлзсэн нь илэрчээ. Энэ талаар Москвагийн улсын их сургуулийн /МГУ/ Орос, Хятадын харилцааны судалгааны төвийн удирдагч Евгений Зайцев “Хятад улсад ирээдүйн удирдагчдын нэр нь албан ёсоор зарлахаас хамаагүй өмнө тодорхой болдог тийм улс төрийн тогтолцоотой. Си Зиньпин ХКН-ын ерөнхий нарийн бичгийн дарга болно гэдэг нь хэдэн жилийн өмнөөс тодорхой болсон боловч тэрээр дөнгөж 2012 оны 11 дүгээр сард албан ёсоор энэ суудлыг эзэллээ. БХАТИХ-ын чуулга, ХКН-ын их хурал гэх мэт иймэрхүү үйл ажиллагаан дээр эрс өөрчлөлт, санамсаргүй зүйл гарахгүй” гэж тэмдэглээд, «жишээ нь индэр дээр Хятадын Борис Ельцин гарч ирээд улс орныг үндсээр нь өөрчлөх цаг үе ирлээ гэх мэт санамсаргүй зүйл гарах магадлал маш бага. Энэ үйл ажиллагааг маш нарийн төлөвлөж, хянуур бэлтгэдэг. Хэрвээ ямар нэгэн санамсаргүй зүйл гарвал түүнийг ХКН-ын удирдагчид өөрсдөө санаачилсан байдаг юм» хэмээн ярилцлага өгчээ.

Мөн БХАТИХ-ын 12 дугаар чуулган дээр нөхөр Си Зиньпинийг Хятадын Цэргийн Төв Зөвлөлийн тэргүүнээр сонгосон байна. Харин 11 дүгээр сард тэрбээр ХКН-ын Төв Хорооны Цэргийн Зөвлөлийн даргаар сонгогдсон. Өөрөөр хэлбэл Си Зиньпин армийг улсын талаас нь ч намын талаас нь ч хянаж байгаа юм. Хамгийн сонирхолтой нь тэр асар богино хугацаанд төрийн бүх эрхийг гартаа авч чадлаа. Жишээ нь: Ху Зиньтао намын тэргүүнээр сонгогдсноосоо хойш хоёр жилийн дараа л ерөнхий дээд командлагч болж байсан билээ. Харин Си Зиньпин өөрийн залгамжлагчаасаа ихэд ялгаатай

байгаа юм. Ялангуяа Си Зиньпиний улс төрийн хэв маяг нь түүнийг ХКН-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар сонгосон өдрөөс эхлэн ажиглагдсан гэж “Власть” сэтгүүлийн ерөнхий редактор Александр Габуев ярьж байна. Тэрээр Төв Хорооны Байнгын хорооны шинэ бүрэлдэхүүнийг танилцуулах ёслолын ажиллагаан дээр сэтгүүлчдэд зориулж товч илтгэл тавьсан. Уг нь хуучин ёсоор бол Төв Хорооны Байнгын хорооны гишүүд бүгдээрээ индэр дээр гарч ирээд дув дуугүй зогсож, сэтгүүлчдийн өмнөөс инээмсэглэж байгаад зургаа татуулаад арилж өгдөг байсан. Харин энэ удаа Си Зиньпин товч үг хэлсэн бөгөөд түүнд марксизм, социализм зэрэг үзэл суртлын үг хэллэг огт байгаагүй. Үүний оронд тэр ажилгүйдэл, эдийн засгийн хөгжлийн удаашрал, тэтгэврийн тодорхой систем байхгүй байгаа, авилга газар авч байгаа зэрэг хүмүүсийн сэтгэлийг бодитойгоор зовоож байгаа асуудлыг ярив. Түүний засгийн газар ойрын 10 жилд эдгээр асуудлуудыг шийдвэрлэхийн төлөө ажиллах болно гэж Си амласан хэмээн Александр Габуев хэлсэн байна.

Нөгөөтэйгүүр БНХАУ-ын дарга Ху Зиньтао илтгэл тавих үеэр биеэ хэрхэн авч явж байсан талаар гадаадын сэтгүүлчид түүний дотор Бээжинд ХКН-ын их хурлын ажиллагааг сурвалжилж байсан «Оросын дуу хоолой» радиогийн тоймч Игорь Денисов ХКН-ын XVIII их хурал олон арван биш, олон зуун жилийн уламжлалд хандаж байгаад анхаарлаа хандуулсан байна.

БНХАУ-ын дарга Ху Зиньтао Ерөнхий нарийн бичгийн даргын хувьд сүүлчийн чухал илтгэл тавих болоход тэрбээр индэр дээр гарч хоёр удаа мэхийн ёслол. “Тэрбээр үг хэлэхийнхээ өмнө ийнхүү мэхийж ёслолыг төсөөлөхэд ч хэцүү байлаа. Мэхийж ёслолыг «шинэ Хятадын» үзэл сурталд харшлах уламжлал хэмээн үздэг байв. Харин Ху Зиньтао уламжлалт үзэл баримтлалд хандаж, тэдгээрийг «4 дэх үеийнхний үзэл суртлын» нэгэн эх сурвалж болгосон юм. Албан ёсны суртал нэвтрүүлэг «хятаджуулсан марксизмтай» харилцаа холбоогоо таслалгүй Күнзийн санааг олонтаа баримталж эхэлсэн. “Өв тэгш нийгэм”, “дунд зэргийн чинээлэг нийгэм” бүтээн байгуулах үзэл баримтлалыг Күнзээс өвлөн залгамжилжээ. Хятад улс Өрнөдийн ардчиллын загвараас өөр улс төрийн өөрийн загварыг эрж байна хэмээн үзсэн юм. Күнзийн сургаалаас залгамжилсан ард түмнээ халамжлан анхаарах «ариун шударга төрийн эр» элитэд үлгэр жишээ болох ёстой. Харин ард түмэн нийгмийн сайн сайхан үв тэгш байдлын төлөө зүтгэх «үйлчлэх төдий засгийн газрын» үзэл баримтлалыг санал болгосон байна.

Ху Зиньтао үнэн хэрэг дээр ийм дүр төрхтэй байхыг

хичээж байсан. Тэрээр амьсгалын цочмог дутлын хам шинжийн өвчлөл /SARS/ гаарсан үед Гуандун мужид очихдоо эмнэлгийн ажилтнуудад мэхийн ёслож байв. Мөн Нью-Йоркод бороо орж байсан ч өөрийг нь угтахаар ирсэн хүмүүст мэхийн ёсложээ. Ху Зиньтао улс орныхоо шилдэг багш нартай уулзахдаа ч бас мэхийн ёслосон байна. Ийнхүү мэхийж ёслох нь Ерөнхий нарийн бичгийн даргын нэг ёсны нэрийн хуудас болжээ. Цөөн үгтэй удирдагч «олон үг хэлэлгүй шаргуу ажиллах» гэсэн Күнзийн зарчмыг баримталж байна гэж Хятадын зарим ажиглагч тэмдэглэжээ. Ийнхүү Күнзийн сургаалыг нэвтрүүлэх биш Мао Зэдун шиг хатуу арга хэмжээ авах замаар л авилгатай тэмцэх хэрэгтэй гэж зарим хүмүүс үзсэн байна. Уламжлалт үзэл баримтлалыг дарангуйлан захиргаадах хандлагыг цаашид бэхжүүлэхэд хэрэглэж мэднэ гэж хятадын либерал сэхээтнүүд болгоомжлох өнгө аяс гаргах болов. Сөрөг үзэл бодлыг няцаан дарах «өв тэгш нийгэм» бүгдэд таалагдахгүй нь ойлгомжтой. Гэвч Күнзийн хэлснээр «ариун шударга төрийн хар хүн» нэг загварын сэтгэлгээ биш өв тэгш үзлийг эрж хайдаг хэмээн Оросын радиогийн тоймч Игорь Денисов бичжээ.

Ху Зиньтао их хурал дээр тавьсан илтгэлдээ «хятадын улс үндэстэн» гэдгийг олонтаа дурьдсан байна. «Хятадын улс үндэстний мөнхийн хөгжлийн төлөө сайн сайхан Хятадыг цогцлоон бүтээн байгуулах» тухай илтгэлийн бүр экологид зориулсан бүлэгт өгүүлжээ. Ийнхүү "Хятадын улс үндэстний их сэргэн мандалт" гэсэн нь Хятад болон хилийн чанадын анхаарлыг татаад байгаа билээ.

БНХАУ-ын дарга "Хятад улс 100 жилийн ойгоороо буюу 2049 он гэхэд баян чинээлэг, хүчирхэг, ардчилсан, соёл иргэншил бүхий, төгс төгөлдөр шинэчлэгдсэн социалист улс болно" гэдгээ зарлаж улмаар шинэ тав дахь үеийн удирдлага хээл хахууль, авлигатай зоримоогоор тэмцэж, бүх талаар баян нийгмийг байгуулж, хүн амын дундаж давхрагыг тэлж, эдийн засгийн хөгжлийн арга хэлбэрээ шинэчлэн өөрчлөлтийг түргэсгэнэ гэдгийг цохон тэмдэглэсэн. Намынхаа үзэл баримтлалд Марксизм-ленинизм, Мао Зедуны үзэл суртал, Дэн Сяопиний онолыг баримталж Хятадын онцлогтой социализмыг байгуулна. Ху Зиньтао одоогийн хөгжиж байгаа түвшинг "Дэлхий дээрхи хамгийн том хөгжиж буй орон" хэмээн дүгнэсэн билээ.

Хятадын "тав дахь үеийн" удирдлагуудын бодлогын шинэ зүйлүүдийг харж болно хэмээн гадаадын шинжээчид ХКН-ын Төв Хорооны шинэ ерөнхий нарийн бичгийн дарга Си Зиньпиний анхны хэлсэн үгийг анхааралтай задлан шинжилж байна. Бээжин

дэх Үндэсний музейд нээгдсэн үзэсгэлэнг үзэж сонирхох үеэр Си Зиньпин үг хэлэхдээ: “Хятад үндэстэнг сэргээхийг” уриалсан байна. “Өөрийнхөө төрийн эрхийг бэхжүүлэх зорилгыг өмнөө тавьсан хятадын удирдагчид уламжлал ёсоор түүхэнд ханддаг юм” хэмээн Москвагийн улсын их сургуулийн дэргэдэх Ази, Африкийн орнуудын дээд сургуулийн орлогч захирал Андрей Карнеев “Голос России” /“Оросын дуу хоолой”/ радиод мэдэгджээ.

Тэрбээр 1949 оны хавар Мао Зэдун тэргүүтэй намын удирдлагууд Бээжинд шилжихээс өмнө байрлаж байсан Хэбэй мужийн Сибайпо тосгонд Ху Зиньтао арван жилийн өмнө ерөнхий нарийн бичгийн даргаар сонгогдсоныхоо дараа шууд очиж байсан. Си Зиньпин мөн л адилхан замаар замнаж байгаа мэт эхлээд харагдаж байна. Гэхдээ Үндэсний музейд нээгдсэн “Сэргэн мандалтын зам” үзэсгэлэнг үзсэний дараа түүний хэлсэн үг асуудлыг арай л өөрөөр тавьлаа. Түүний өмнөх удирдагч Сибайпод очихдоо хувьсгалт, коммунист өнгөрсөн үедээ ихээхэн анхаарал хандуулсан байдаг. Харин Си Зиньпиний хэлсэн үгэнд урьдын зуршил болсон улс төрийн тэмдэглэгээ байсангүй. 1840-1842 онуудын “хар тамхи”-ны дайнаас авахуулаад өнөөг хүрсэн Хятад улсын түүхэн замналыг харуулсан үзэсгэлэнг үзсэнийхээ дараа Си Зиньпин хөгжлийн социалист ирээдүйн тухай биш “Хятад мөрөөдөл”-ийн тухай ярьсан. Хэлсэн үгээс нь харахад цаасан дээр бичсэн бус өөрийнх нь үг гэж хэлж болохоор байна. Си Зиньпин өөрийн хэлсэн үгээ олон нийтийн дунд ихээхэн тархсан “Хятад улс хангалттай доромжлууллаа одоо агуу их гүрэн хэмээх нэр төрийн төлөө итгэлтэй урагшилж байна” гэсэн сэдэвд тулгуурласан байна. Си Зиньпин Хятадын өнөөгийн зорилгыг “хоцрогсодыг арилгана, зөвхөн урагшлан хөгжиж байж л өөрийгөө харуулж чадна” гэж тодорхойлжээ. “Хүн бүрийн хувь заяа, ирээдүй улс орны болон үндэстний хувь заяа, ирээдүйтэй шууд холбоотой. Улс үндэстэн сайн байвал бүгдээрээ сайн байна гэсэн үг” хэмээн Си Зиньпин онцлон тэмдэглэсэн байна.

Ерөнхий нарийн бичгийн даргын хэлсэн үгээс харахад “хятад мөрөөдөл” гэгч хамт олны үнэ цэнэтэй зүйл, нийт үндэстний ашиг сонирхол дээр бий болох ёстой юм байна. Си Зиньпиний хэлсэн үгээс нийгмийн тогтвортой байдлын асуудалд удирдлагууд нь нэлээд түгшиж байна гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна гэж Москвагийн Их сургуулийн дэргэдэх Ази, Африкийн орнуудын дээд сургуулийн орлогч захирал Андрей Карнеев “Оросын дуу хоолой” радиод ярилцлага өгчээ. Одоохондоо шилжилтийн үеийн тухай яригдаж байна. Ер нь ирэх жилийн 3 дугаар сар хүртэл удирдагчид

төр засгийг бэхжүүлэх, дээдсийг нягтруулах, өөрсдийнхөө эргэн тойронд үндсэн бүлэглэлүүдийг нэгтгэх зэрэг гол зорилтуудыг эхний ээлжинд шийдвэрлэх ёстой юм. Энэ үе бол хуваагдах биш эвлэлдэн нэгдэх үе юм гэж тэрбээр ярьсан байна.

Мөн түүнчлэн гадаадын зарим шинжээчид Си Зиньпиний эхний алхам нь үндсэрхэг хандлагатай байна хэмээн дүгнэж байв. Үндсэрхэг үзэл рүү бага зэрэг хэлбийж байгаа нь гадаад дотоод бодлогодоо консерватизмыг бэхжүүлнэ гэсэн үг биш гэж тэдгээр шинжээчид үзэж байна. Шинэ удирдлагуудын хувьд хямралын үед төр засгаа бэхжүүлэх нь гол зорилт гэдгийг харуулах нь чухал байгаа, тухайн үедээ өөрчлөлт шинэчлэлийн суурь болсон Хятадын өмнөд нутаг руу Си Зиньпин эхлээд аялсан нь консерватив эргэлт болохгүй гэдгийг харуулж байна хэмээн Андрей Карнеев үзсэн байна. Си Зиньпин сонгодсоныхоо дараа улс төрийн шинэчлэл, ардчиллын талаар нэг ч үг цухуйлгаагүй байгаа нь одоохондоо энэ хүрээнд өөрийн залгамжлагчдын нэгэн адил консерватив байдалтай байгаа бололтой.

Нөгөөтэйгүүр гадны эрдэмтэн судлаачид хятадын шинэ удирдлагын нэн чухал зорилт бол эдийн засгийн шинэтгэлийг эрчимжүүлэх, ирэх 10 жилийн өнгийг хэрхэн тодорхойлох тухай өөрсдийн санал дүгнэлтийг дэвшүүлсээр ирлээ.

ХКН-ын шинэ ерөнхий нарийн бичгийн дарга Си Зиньпин сэтгүүлчдэд хандаж хэлсэн анхны үгэндээ эдийн засгийн хөгжлийн чиг бодлогыг үргэлжлүүлнэ хэмээн мэдэгдсэн юм. Хэрэв намын өмнөх удирдагч амлалтаа хэрэгжүүлж чадсан бол Си Зиньпиний хувьд амласан бүхнээ биелүүлж чадахгүй нөхцөл байдалтай тулгарч магад гэж гадаадын судлаачид үзэж байна. Тухайлбал: өнгөрсөн үед бий болгосон Хятадын эдийн засгийн хөгжлийн загвар нь үеэ өнгөрөөсөн гэж шинжээчид үзэж байна. Хятадын эдийн засгийн өнөөдрийн тулгуур нь дотоодын хэрэглээг хөгжүүлэх явдал юм. Европ, Америкийн үндсэн хэрэглэгчид их хэмжээний мөнгө зарцуулахад бэлэн бус нөхцөлд гадаад худалдаанд найдвар тавих нь ашиггүй гэдгийг 2008 оны хямрал харуулсан билээ.

Хүн амынхаа орлогын түвшинг нэмэгдүүлэх нь зөвхөн Хятадын эдийн засгийг ч өсгөөд зогсохгүй бусад улс орнуудад тогтвортой байдлын баталгаа болно гэдэгт Оросын Улс төрийн прогноз судалгаа шинжилгээний хүрээлэнгийн захирал Андрей Виноградов итгэлтэй байна. Тэрбээр: “дэлхий нийтээрээ Хятадыг эдийн засгийн хөгжлийн зүтгүүр гэж үзэж байна. Хэрвээ БНХАУ-ын эдийн засаг өсвөл хямралын үед бүгдийг нь дэмжих болно. Одоо тус улсын өмнө

дотоодын хэрэглээ болон эдийн засгийн өсөлтийн тэнцвэрийг олж, дотоод, гадаад зах зээлд чиглүүлэх хүнд асуудал тулгараад байна” гэжээ.

Шинжээчдийн таамаглаж буйгаар ойрын жилүүдэд хятадын ДНБ-ий өсөлт ойролцоогоор 7-7,5%-иар өсөөд дараа нь буурч эхлэх ажээ. Хятадын статистик тоо баримт бол ил тод биш, зөвхөн БНХАУ-ын удирдлагуудын зөвшөөрсөн тоог дурьддаг гэдгийг шинжээчид сануулсаар байгаа юм.

Шинэ удирдлагуудын хувьд хямралын үед төр засгаа бэхжүүлэх нь гол зорилт гэдгийг харуулах нь чухал байгаа гэж Москвагийн улсын их сургуулийн дэргэдэх Ази, Африкийн орнуудын дээд сургуулийн орлогч захирал Андрей Карнеев үзэж байна. “Хятад үндэстний сэргэн мандалт” гэдэг нэр хүндтэй сэдвийг өөрийн хэлсэн үгэндээ ашиглахдаа ч Си Зиньпин дээрхийг л нотлохыг оролдсон юм. 1978 оны 12 дугаар сард болсон ХКН-ын Төв Хорооны 11 дэх удаагийн 3 дугаар чуулганы бүгд хуралдаан дээр Дэн Сяопины үг хэлж байгаа хөрөг зургийн өмнө Си Зиньпин зогсож байгаад үгээ хэлсэн нь учиртай. Яг энэ үеэс л шинэчлэл, нээлттэй ил тод байдал эхтэй билээ гэж тэр ярьсан байна.

Юуны өмнө БНХАУ гадаад бодлогоо эдийн засагжуулахад анхаарлаа хандуулж байна. Олон улсын эдийн засгийн хэрэг эрхлэх газрыг БНХАУ-ын Гадаад Харилцааны Яаманд байгуулжээ. Энэ алхам Хятадын удирдлагаас эдийн засгийн дипломат ажиллагаанд улам их анхаарал тавьж байгааг тусган харуулсан гэж Оросын ШУА-ийн Алс Дорнодын хүрээлэнгийн дэд захирал Сергей Лузянин үзэж байна. Шинэ газрыг байгуулах тухай ХКН-ын XVIII их хурал нээгдэхээс нэг сарын өмнө зарлаж мэдээлсэн байна. Их хурлын үр дүнд засгийн эрхэнд гарсан шинэ үеийнхэн ойрын 10 жилийн улс орныхоо гадаад дотоод бодлогыг тодорхойлох болно. Энэ завсар Хятад улс ДНБ-нийхээ хэр хэмжээгээр одоо дэлхийд тэргүүлж байгаа АНУ-аас давах тэмдэглэлт үйл явдал болно гэж эдийн засагчид таамаглаж байна. Хятадын дотоодын хөгжлийн хэрэгцээ, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах явдал дипломат ажилтнуудаас эдийн засагт илүү их анхаарал тавих гол шалтгаан болсон гэдгийг тэмдэглэсэн.

Гадаад бодлогын бусад чиглэлийн нэгэн адил эдийн засгийн дипломат ажиллагааны зорилго, зорилтыг хятадын нийгэмд радикал эх оронч ба үндсэрхэг үзэл гaarсан нөхцөлд тодорхойлох юм. Энэ нь удирдлагад нөлөө үзүүлэх нь дамжиггүй. Харин Хятадын 5 дахь үеийн удирдагчид тэсвэр тэвчээртэй байж, хүчирхэг боловч

даруухан хариуцлагатай гүрэн улсын дүр төрхийг урагш ахиулах нь улс орны ашиг сонирхолд нийцэж байгааг ойлгож байна гэж профессор Сергей Лузянин үзэж байна.

Хятад улсад хөрөнгө оруулалтын үсрэлт бас хор хохирол дагуулах болжээ. Тухайлбал үйлдвэрлэлийн илүүдэл нь гадаадын зохисгүй тухайн байдалтай холбоотойгоор олон үйлдвэр дампуурч, ДНБ унахад хүргэж мэднэ. Иймээс хятадын шинэ удирдлагын нэн чухал зорилт эдийн засгийн шинэтгэлийг эрчимжүүлэхэд оршино. Шинэтгэл хөгжлийг улам тэнцүү болгоход чиглэгдэх ёстой гэж Оросын ШУА-ийн Алс Дорнодын хүрээлэнгийн дэд захирал Сергей Лузянин «Оросын дуу хоолой» радиод өгсөн ярилцлагадаа тэмдэглээд, «эдүгээ Хятад улс дорвигүй эдийн засаг, түрэмгий экспорт, технологийг хуулбарлан ашиглах явдалд тулгуурласан хуучин ба шинэ загваруудын уулзвар дээр байна. Шинэ загвар дотоодын эрэлтийг ашиглах, дэлхийн инновацийн төвийг Хятад улсад байгуулах явдлыг түшиглэж байна. Үүнд: Хятад улс үндэстний сэтгэлгээтэй холбоотой тулгуур асуудал гарлаа. Хятадууд бол хатуу сахилгатай маш сайн гүйцэтгэгч, зиндааг чанд баримтлагч, үйл явц технологийг сайн хуулагч гэдгийг өмнөх хэдэн арван жил нотлон харуулав. Гэвч тэд бүтээлч үйл ажиллагааг систем болгоход сайн биш, бас дээр нь хариуцлага өөртөө ногдуулах, эрсдэлтэй боловч урагш ахихад туслах шийдвэрийг санаачлах дургүй» гэжээ. Энэ бүхэн инноваци маягийн эдийн засаг Хятад улсад байгуулахад саад болно гэж профессор Лузянин үзэж байна.

Бусдын боловсруулалтыг хуулан ашиглаж лассан Хятад улс дэлхийн «фабрик»-аас инновацийн төв болж хувирах амаргүй замыг арга буюу туулах юм. Түүнээс гадна Хятад улс эдийн засгийн шинэ загварыг дөнгөж байгуулж эхлэв. Эдийн засгийн өнөөгийн загварын зохисгүй тал болон гадаадын зах зээлээс хэт хамааралтай байх явдлын уршиг мэдрэгдэнэ. Си Зиньпиний баг эдгээр саад тотгорыг давж, хөгжлийг тогтонги болгож, нөөцийн ашиглалтад шинээр хандах үзэл санааг төлөвшүүлж, экологийн ба хүн ам зүйн асуудлыг шийдвэрлэх ёстой. Өсөлтийн хурдыг хамаагүй нэмэгдүүлэх зорилго тавихгүй. Гэвч хятадын удирдлага нийгмийн тогтонги байдлыг хэвээр хадгалахад зайлшгүй өсөлтийн хэмжээг хангах ёстой гэж доктор Лузянин дүгнэлээ.

Нөгөөтэйгүүр Хятадын хөрөнгийн бирж дээрхи юаний үнэт цаасны арилжаа нь гадаадын хөрөнгө оруулагчдын чиг шугамыг тодорхойлдог билээ. Чухамдаа хятадын хөрөнгө оруулагчдын зүгээс тэд өрсөлдөөнийг олж харваас энэхүү тоглоом сая сэтгэл

татаж, хорхой хүргэх аж. Ийм орчныг байгуулах нь хятадын эрх баригчдын хувьд хамгийн хүнд зорилт болоод байна. «Өнөөдрийн байдлаар Хятадын төлөвлөгөөнүүд нь зарчмын хувьд хөгжиж байгаа санхүүгийн төвийн хувьд болон гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхолын хувьд нийцэж байна. Ингэхдээ дэлхийн санхүүгийн зах зээл дээрх байдал нь бусад олон хөгжиж байгаа орнуудын нэгэн адил, хятадын зах дээр идэвхитэй хөрөнгө татахад нөлөө үзүүлэхгүй байна. Хязгаарлалтыг цуцлаж, квотыг нэмэгдүүлж байгаа энэ байдал нь гадаадын хөрөнгө оруулагчдад Хятадын дотоодын хөрөнгийн захын худалдааг ашиглах боломжуудыг олгож байна» гэж Оросын санхүүгийн шинжээч Игорь Костиков үзжээ.

Хятадын шинэ удирдагчдаас дэлхий дахин хүлээж байгаа бас нэг алхам бол үндэсний валютаа бэхжүүлэх талаар авах арга хэмжээ билээ. Тэгэхдээ энд дэлхийн зах зээлийг алдах аюул байгаа гэдгийг Хөрөнгө оруулалт санхүүгийн “Метрополь” компанийн шинжилгээний департаментийн захирал Марк Рубинштейн анхааруулж байна. Үүнд: “Энэ асуудал зөвхөн эдийн засгийн ч бус улс төрийн асуудал юм. Хэрвээ хятадын бараа гадаадад үнэтэй болвол тэдний хэрэгцээг багасгаж хятадын эдийн засгийн хөдөлгүүр болсон экспортыг хорогдуулж мэдэх юм” гэж тэрбээр ярьжээ. Улмаар хэрэглээний нөхцлийг сайжруулахын тулд улс доторх зээллэгийг хөгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. “Банкуудыг хэрэглээний зээллэгэд урамшуулах шаардлагатай байна. Бүр албан газрын батлан даалттай зээллэгийн хагасыг нь хэрэглээний зээллэгэд шилжүүлж болох юм. Хувийн зээлдэгчдийн хүүг ч багасгах шаардлагатай болж мэднэ” гэж мэдэгдсэн байна.

“Валютын дайны” тухай хэзээ ч мартаж болохгүй. Хятад улс Вашингтонд зохих хэмжээний буулт хийгээд байгаа гэхдээ америкчууд тус улсаас илүү их буулт хүлээх хэрэггүй л болов уу. Экспорт унана гэдэг нь ямар аюултайг Москвагийн их сургуулийн дэргэдэх Ази, Африкийн орнуудын дээд сургуулийн багш Александр Габуев ийнхүү тайлбарлаж байна. “Экспорт бол үйлдвэрлэл нэлээд гүн нягтарсан БНХАУ-ын зүүн өмнөд нутагт тус улсын иргэдийг ажлын байраар хангаж байгаа салбар юм. Хэрвээ экспорт огцом унавал тэнд нийгмийн давалгаа үүснэ. Энэ давалгааг хэрхэн яаж дарах нь ойлгомжгүй байна. Энэ талаас нь авч үзвэл хятадын удирдлага өөрсдийгөө эвгүй занганд оруулах болно. Гэхдээ байдал хэрхэн өрнөхийг бид харах болно. Ер нь нөхцөл байдал хүндрэлтэй байна” гэжээ.

Хятадын бараа Европ тивд ямар үүрэг гүйцэтгэж байгааг

мартах ёсгүй, Бээжин ямар нэг асуудалтай тулгарахыг тэнд нэг их хүсэхгүй байгаа. Өнөөдөр хятадын байдал дэлхий дахиныг мөнгөний ханшийн уналтаас хамгаалж байгаа гэж эдийн засагч Дмитрий Тратас үзэж байна. Тэр “Америк, Европын эдийн засаг мөнгөний ханшийн уналтыг хангалттай доод хэмжээнд барихад нь Хятад улс туслаж байгаа юм. Европийн бүсийн болон АНУ-ын санхүүгийн зохицуулагчид сүүлийн үед санхүүгийн зах зээлийг бэлэн мөнгөөр асар хүчтэй дүүргэж байсан нь нууц биш ээ. Онол ёсоор бол үүнээс болж мөнгөний ханш зад тавих ёстой гэтэл ийм үйл явдал болохгүй байна. Энэ нь хятадын экспортын хямд бараанаас шууд шалтгаалж байгаа” гэсэн дүгнэлтэнд хүрчээ.

Олон улсын Moody’s рейтингийн агентлагийн үнэлснээр 2013 онд Ази-Номхон далайн бүс нутаг дэлхийн өөр бусад бүс нутгаас илүү эрчимтэй хөгжих явдал юм. Хятад улсын өсөлт удааширсан ч хурд нь эрс унахгүй. Ази-Номхон далайн бүс нутгийн орнууд макро эдийн засгийн өндөр үзүүлэлтийнхээ ачаар эрсдлийг давж мэднэ гэж Moody’s агентлаг үзэж байна. Түүнээс гадна эдгээр улс өсөлтийн дотоодын эх сурвалжид илүү их тулгуурлах болсон гэж агентлагийн дэд ерөнхийлөгч Кристиан де Гузман мэдэгджээ. Хятадын макро эдийн засгийн байдалд өгсөн үнэлгээний тухайд гэвэл Moody’s агентлагийн таамаглал Олон улсын валютын сангийн шинжээчдийн дүгнэлттэй нийцжээ. Бүр 2012 онд тэд Хятад улсын эдийн засгийн хөгжлийн хурд гарцаагүй намжихад анхаарлыг хандуулсан билээ. Хятад улсын ДНБ-ий ойрын өсөлтийн барагцаалбал тэн хагас нь капиталыг нэмэгдүүлэхэд ногдсон гэж ОУВС тэмдэглэсэн байна. Өөрөөр хэлбэл компаниуд хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх биш үйлдвэрлэх хэрэгслийг нэмэгдүүлэхэд хөрөнгө оруулжээ. Ийм стратеги илүүдэл ажиллах хүчинтэй нөхцөлд үр дүнд хүрнэ. Харин 2015 оноос хойш Хятад улсад ажиллах хүчин багасаж, энэ улс өрсөлдөх давуу талаа алдаж мэднэ гэж хүн ам зүйчид үзэж байна. Түүнээс гадна дэлхийн эдийн засгийн доройтол хятадын гадаадын зах зээлийг баримжаалах үйлдвэрүүдийг хамрахгүй байж чадахгүй. Ийм хандлага Ази-Номхон далайн бүс нутгийн эдийн засгийг бас хамарсныг Moody’s агентлагийн шинжээчил онцолжээ. Тэдний үнэлснээр бүс нутгийн корпорациудын өрсөлдөх чадварын үзүүлэлт тогтонги хэвээр байсан ч дэлхийн эдийн засгийн хөгжлийн хурд удааширсан явдал бүтээгдэхүүнээ гадаадад гаргадаг компаниудын байдалд зохисгүй нөлөөлж мэднэ.

БНХАУ нь эдийн засгийн өсөлтөөрөө дэлхийд тэргүүлэх тухай прогноз таамаглалыг дэлхийн улс орнууд дэвшүүлсээр байна.

Тухайлбал: бүр 2017 онд АНУ эдийн засгийнхаа хэр хэмжээгээр БНХАУ-ын дараа орно гэж “Pricewaterhouse Coopers консалтинг компани”-ий шинжээчид таамаглал дэвшүүлж байна. Харин дэлхийн эдийн засагт хүчний сэлгээ үүгээр төгсөхгүй гэж тэд үзээд, 2050 он гэхэд БНХАУ, АНУ, Энэтхэг улсуудын эдийн засаг тэргүүн гурван байрыг эзэлнэ гэж тус компанийн шинжээчид дүгнэсэн байна. Тэгвэд АНУ, БНХАУ-ын дараа хоёрдугаарт орж, Энэтхэг улс өнөөгийн 10 дугаар байрнаас эрс урагшилж гуравт орох болно. Хэтдээ БНХАУ-ын ДНБ бүр 54 их наяд хүрнэ. Эдүгээ мөн үзүүлэлт 6 их наяд хүрэхгүй байгааг харьцуулж үз л дээ. Хятад улс эдийн засгийн хөгжлөөрөө дэлхийд тэргүүлнэ гэж Орос-Хятадын танхимын хариуцлагатай нарийн бичгийн дарга Сергей Санакоев үзэж байна. Тэрээр Хятад улс ойрын үед ийм өндөр амжилт гаргахыг тайлбарлан хэлэхдээ «Улс үндэстэн ажиллаж, үйлдвэрлэн бүтээж байна. Энэ нь өсөлтийн нэн чухал хүчин зүйл юм. Мэдээжээр дэлхийн санхүүгийн хямрал гарсан нөхцөлд Хятадын бараа таваарын эрэлт дэлхий даяар унасан нь Хятадын эдийн засагт нөлөөлсөн. Гэвч дотоодын эрэлт хэрэгцээг баримжаалах шуурхай арга хэмжээ авч, зээлийн уян хатан бодлого явуулж, эдийн засгийнхаа өсөлтийн жилийн дундаж хурдыг 7-10 хувь байлгах боломж олгов. Энэ нь бүр 2017 онд Хятад улс тэргүүлэх эдийн засагтай болоход хангалттай» гэсэн байна.

Нөгөөтэйгүүр БНХАУ-ын шинэ удирдагч Си Зиньпин, Ли Кэцян нар анхны хэлсэн үгэндээ авилгатай хийх тэмцэлд гойд анхаарал тавьсан билээ. Авилгатай хийх тэмцэл болон «цэвэр ариун засгийн газрыг» эмхлэн байгуулах явдал «хятадын мөрөөдлийг» биелүүлэх замд хэрэгжүүлэх нэгэн зорилго гэж БНХАУ-ын дарга Си Зиньпин чуулганыг хаах ёслол дээр, Төрийн зөвлөлийн ерөнхий сайд Ли Кэцян сэтгүүлчдийн өмнө хэлсэн үгэндээ онцолсон нь тохиолдлын хэрэг биш юм. Үүнийг бүгд хүлээн зөвшөөрөх улмаар ийм замаар улс орноо хүчтэй донсолгооноос аварч болно гэж удирдагчид үзжээ.

Ли Кэцян сэтгүүлчдийн өмнө үг хэлэхдээ, Күнзийн цэцэн мэргэн сургаалд хандсан нь «хятадын мөрөөдөл», «хятадын онцлогтой социализм»-ын үнэт зүйл төдийгүй урьдын оюуны өвийг эргэцүүлэн бодоход тулгуурлаж байгааг харуулсан гэж ажиглагчид үзжээ. Ли Кэцян авилгатай хийх тэмцлийн төлөө засгийн газрын хариуцлагын талаар өгүүлсэн юм. Тэрбээр эртний мэргэдэд бас хандаж «Түшмэлийн албан тушаал ба баяжих эрмэлзэл бол хоёр өөр зам гэж эрт дээр үед өгүүлж байв. Түшмэл нэгэнт төр засгийн албан тушаал хашиж байгаа бол олон нийтийн ашиг сонирхолд л

үйлчилж, баяжих эрмэлзэлээ орхих ёстой. Биднийг бүх нийгэм, хянаж шалгаасай. Хахууль авч хахуульдагч болохгүй байх, авилгатай тэмцэх зэрэг механизмыг боловсронгуй болгох нь зайлшгүй чухал. Хахуульдах ажиллагаа ба хахуульдагчдыг хатуу шийтгэх хэрэгтэй» гэж хэлсэн байна.

“Хятадын мөрөөдөл” бол нэлээд хийсвэр үзэл санаа гэж олонх шинжээч тэмдэглэжээ. Энэ үзэл санаа ямар агуулгатай болохоос төр засгийн нэр хүнд болон Хятадын өнөөгийн тогтолцооны байдал, тогтвортой хөгжил шалтгаална. Авилгатай тэмцэх бодлого түшмэдийн эрхийг хязгаарлах зохих механизм, тэдний ажлыг ил тод болгох арга хэмжээгээр батлагдвал иргэд ийм бодлогыг нааштай хүлээж авах нь дамжиггүй. Өнөөгийн удирдагчид «цэвэр ариун засгийн газрыг «эмхлэн байгуулах эсэхээс хүний сайн сайхан аж байдал, улс орны тогтвортой хөгжил хамаарахыг олонх нь ойлгож байна. Тэгсэн цагт «эх оронч бодит бодлого» баримтлах Хятадын шинэ удирдагчид үүргээ биелүүлж болох юм.

Улмаар ХКН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга Си Зиньпин хуралдаан дээр шүүх, прокурорын газар, аюулгүй байдлын байгууллагуудад хандан хууль хөдөлбөргүй даган мөрдөхийг уриалсан бөгөөд Си Зиньпин авилгатай тэмцэж, төр иргэний хоорондох зайг ойртуулахаар ажиллана гэж амласан. Тэгснээр шинэ удирдлага авилга, хээл хахуультай шийдвэртэй тэмцэнэ гэдгээ харуулж эхэллээ. Их хурлын дараа бүс нутгийн төрийн албан хаагчид хэдэн арваараа авилгын хэргээр мөрдөн байцаах газрын анхаарлын төвд орлоо.

Ийнхүү ХКН авилгатай улам хүчтэй тэмцэх болсон нь Хятадаас капиталаа гаргахад ташуур өгч, хахууль аван улсын сангийн хөрөнгө тоносон түшмэд үл хөдлөх хөрөнгөө яаралтай худалдаж эхлэв. Урьдын харилцаа холбоо нь хөрөнгөө гадаадад нууцаар гаргаж, хилийн чанадад суух бичгийг тойруу далдуур замаар авах боломж тэдэнд олгох болжээ. Тансаг орд харшаа 2012 оны 11 дүгээр сараас худалдаж эхэлсэн бөгөөд 12 дугаар сар гэхэд худалдаа өргөжин эрчимжсэн гэж ХКН-ын Төв Хорооны Сахилга батыг хянан шалгах хорооны илтгэлд тэмдэглэсэн байна.

Томоохон зургаан хотын дарга, дэд дарга нарыг төдөлгүй огцруулав. Түшмэдийг баривчилж, албан эрхээ хэтрүүлж, улсын хөрөнгө шамшигдуулсан тул эрүүгийн хариуцлагад татжээ. Өнгөрсөн онд 100 гаруй авилгачдын талаар ийм арга хэмжээ авсныг Оросын Улс төр судлал, прогноз төвийн удирдагч Андрей Виноградов дурьдаад: «авилга бүх төрлийн засаг - хошуу мужийн удирдлага,

дээд удирдлагад нэвтэрсэн байна. Авилгатай хийх тэмцлийн тухайд гэвэл амжилт гаргаагүй мэт сэтгэгдэл төрж магадгүй. Энэ нь ХКН-аас авилгатай муу тэмцэж байгаа биш авилга төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлд шилжих үеийн зайлшгүй дагуул болсонтой холбоотой. Хятад улс ийм нийгмийн нэг» юм гэв.

Хятад улсад баривчилсан авлигачдын тоо өсөн нэмэгдсээр байна. Үүний сацуу шилмэл орд харшаа худалдаж, мөнгө хөрөнгөө хилийн чанадад гаргасан түшмэдийн тоо ч нэмэгдэж байна. 2012 онд улсын 10 мянга орчим албан хаагч ийм ажиллагаа явуулж, улс орноосоо зугтан зайлжээ. Тэд улсад 160 тэрбум гаруй долларын хохирол учруулсан байна. Байдлаас харахад капитал гадагшаа гарах үйл явц зогсохгүй байна. Харин ч Бээжин, Шанхай, Гуанжоугийн үл хөдлөх хөрөнгийн зах зээлүүд орон сууцны шилмэл байшин, тансаг орд харш худалдах саналаар дүүрчээ. Тухайлбал: Шар тэнгисийн эрэг хавийн нэрд гарсан Бэйдахэ амралт сувиллын газар болон Хайнань арал дахь үл хөдлөх хөрөнгөө худалдахыг олон этгээд оролдож байна. Худалдан авагч бэлэн мөнгөөр авбал өртөг нэлээд буурах юм. Авлигачид орлогоо хилийн чанадад их хэмжээгээр гаргах ажиллагаа компани, үйлдвэрлэл эрхлэгчид капиталаа Хятад улсаас гаргахтай цаг хугацааны хувьд давхцаж байна. 2012 онд тэд 225 тэрбум доллар гаргажээ. Энэ нь Хятад улсын 2011 оны ДНБ-ий бараг 3 хувь гэсэн үг. Капиталыг нууц сувгаар гадаадад гаргаж байгаа жишээ олон байгаагаас дурьдвал, бэлэн мөнгийг гаалийн хяналт шалгалтгүйгээр хувийн онгоцоор тээвэрлэн шилжүүлэх гүүрийг байгуулжээ. Түүнчлэн их хэмжээний бэлэн мөнгө цүнхэндээ хийж хил давуулах этгээдүүдийн үйлчилгээ эрэлт хэрэгцээтэй байна. Компаниуд ажилтнуудынхаа хөрөнгө мөнгийг хилийн чанадад гуйвуулах банкны хөрөнгөд багтаах тохиолдол олонтаа гарч байна. Түүнээс гадна компаниудын эзэд хувьцаагаа Хонгконг, Сингапур, Нью-Йоркийн хөрөнгийн биржийн зах зээлд худалдаж хөрөнгөтэй болох нь ердийн ажиллагаа болжээ. Хэргийг нь шүүн таслах ажиллагаанаас эмээж зугтсан улсын түшмэд болон хөрөнгөө гадаадад гаргаж байгаа үйлдвэрлэл эрхлэгчид хөрөнгөө үл хөдлөх хөрөнгөд оруулж байна. Тухайлбал өнгөрсөн онд хятадууд 7 тэрбум доллараар үл хөдлөх хөрөнгө авсан тухай АНУ-ын үндэсний худалдагчдын холбоо мэдээлжээ.

«Шинэ хятадуудын» байрлах орон сууцны бүхэл бүтэн хорооллууд Лондон болон Франц, Итали, Грек, Кипр зэрэг улсын амралт сувиллын газруудад бий болсоор байна. Тэгэхдээ орд харшийг тусгай төслөөр барьж, эдлэнг хятад маягийн сэрүүн асар

болон алтан загастай цөөрмөөр чимэглэж байна. Энэ нь орон нутгийн энгийн оршин суугчдын хувьд хятадын түрэмгийлэл гэгчийн тод нотолгоо болж, хятадын эсрэг үзэл санааг гааруулж байна хэмээн гадны хэвлэл мэдээллийн хэрэгслэлүүд мэдээлж байна.

ХКН-ын XVIII их хурал дээр экологийн соёл иргэншлэлийн бүтээн байгуулалтыг бүхий талаар хийх асуудлыг дэвшүүлж тавьсан билээ. Өнөөдөр Хятадын байгалийн тэнцвэрт байдал, цаг уурын түүхэнд гарч байгаагүй үзэгдэл, шороон шуурга, агаарын бохирдол хирээс хэтэрч байгаа талаар гадны хэвлэл мэдээллийн хэрэгслэлүүд мэдээлсээр байна. Хятад улс орчны бохирдлоосоо ангижирсан тэр цагт ажиглагдаж буй өмнө цаг уурын түүхэнд гарч байгаагүй байгалийн ер бусын үзэгдлүүдтэй тэмцэхэд хялбар байх болно. Хятадын төвийн болон зүүн бүс нутгуудын өтгөн манан, тортог болон утаатай тэмцэх ажлыг Оросын шинжээчид ийн тайлбарлаж байна.

Хятадын агаарын маш өндөр даралт болон хортой хий ба хортой бодисуудын хэмжээ их байна. Тухайлбал: автомашины утааг хэлж болно гэж Оросын ШУА-ийн Алс-Дорнодын хүрээлэнгийн шинжээч Игорь Ушаков ярьж байна. Тэрээр 20 сая хүн амтай Бээжинд 4 сая автомашин явдаг бөгөөд энэ нь бусад хотуудын тээврийг оруулалгүйгээр гаргасан тоо гэдгийг сануулав. Энэ нь ямар нэгэн байдлаар экологийн сүйрэл гэж тэр тэмдэглэжээ. «Энэ нь хүний буруу үйл ажиллагаатай холбоотой. Үзэгдэл нь хиймэл шинж тэмдгийн нэгэн адил байгалийн шинж тэмдэгтэй байдаг. Энэ бол хятадуудын хувьд тулгамдсан асуудал. Одооноос нийгмийн үр дагавар гарч эхлээд байна. Хятад улсад өнгөрсөн жил байгаль орчны байдалтай холбоотой эсэргүүцлийн жагсаалын тоо 30 хувиар өсчээ.

Усны бохирдлын талаар “Чайна дейли” сонинд Шар мөрний өмнүүр оршин суудаг хүмүүсийн орчин нь хүнд металлын улмаас бохирдсон тул 50-иас илүү наслахгүй хэмээн бичжээ. Өнгөрсөн хавар Бээжинд болсон манангийн тухай хятадууд ил тод бичиж, ХКН-ын их хурал дээр сайхан Хятадын тухай ярьж байсан, гэтэл тэнгэр тэр чигээрээ хар байх юм гэж асуудлыг нэлээд шулуухан тавьж мэдээлсэн байна. Хятадын тэнгэрийн манан, утаа, униар энэ бүхэн нь шинжээчдэд шинэ түгшүүр дэлдэх шалтгаан болж байна. Эрчим хүчийг болон бусад салбаруудыг яаралтай илүү цэвэр эрчим хүчний эх үүсвэрт шилжүүлэх шаардлагатай байна гэж “Дэлхийн онгон байгаль сан”-гийн Түлш-эрчим хүчний цогцолборын экологийн бодлогын хөтөлбөрийн тэргүүн Алексей Книжников “Оросын дуу

хоолой” радиод ярилцлага өгчээ. Тэрбээр «Хятадын эрчим хүч одоо болтол үндсэндээ нүүрсэн дээр суурилж байгаа. Энэ нь агаарыг маш их хэмжээгээр бохирдуулж байдаг нь ойлгомжтой. Үүнтэй холбогдуулан экологийн цэвэр түлшийг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг тэмдэглэх нь зүйтэй юм. Хятад улсад эрчим хүчийг нүүрснээс байгалийн хий рүү шилжүүлэх хийн хоолойнуудыг барих хэрэгтэй» гэжээ.

Мөн сүйрэл гарах заналхийлэл байгаа тухай Оросын ШУА-ийн Алс Дорнодын хүрээлэнгийн шинжээч Андрей Островский сэтгүүлчийн асуултанд хариулахдаа, “одоо экологийн сүйрлийн бүсэд Хятадын нутаг дэвсгэрийн долооны нэг орчим хувь хамрагдаж байна. Ингэхдээ Бээжинд хамгийн өндөр түвшинтэй байгаа бөгөөд экологийн аюулын зургаа дахь түвшинтэй байгаа, хэрвээ салхигүй, агаарын өндөр даралттай байвал сүйрэл гарч болзошгүй юм” гэсэн байна.

Нөгөөтэйгүүр “Жунго зинзи шибао” сонинд “нэг гэр бүл - нэг хүүхэд” зарчмаар хүүхэд төрөлтийг хязгаарлах бодлогоос аль болох түргэн татгалзахыг уриалсан хятадын эрдэмтдийн нийтлэл гарсан байна. Үүнд дээрх бодлогоос татгалзсанаар хүн амын бүтцэд өндөр настай хүмүүсийн хувийг багасгаж, ажиллах хүчин дутагдах асуудлыг шийдвэрлэж болно гэж бичжээ. Хятадын шинжээчид хүүхэд төрөлтийг хязгаарлах бодлогыг зөөлрүүлэх асуудлыг аль хэдийнээ хэлэлцэж эхлээд байна. Гэвч асуудлыг нэн даруй шийдвэрлэвэл зохино гэсэн өгүүллийг анх удаа нийтэлжээ. Ялангуяа БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн дэргэдэх Хөгжлийн судлалын төвийн ажилтнууд хүн ам зүйн бодлогыг хянаж үзэхийг санаачилсан нь олны анхаарлыг татсан юм. Энэ нь засгийн газрын эрдэм шинжилгээний нэгэн төв аж.

Шинжээчид томоохон хотуудад хүүхэд төрөлтийн коэффициент эрс доройтсоныг онцолсон байна. Энэ үзүүлэлт улс даяар 1,6 % ойртож, хүн амын өрийн хорогдлыг нөхөх аргагүй болсон. 1970-аад оны сүүлчээр хүүхэд төрөлтөд хатуу хяналт тавьж эхэлсэн нь хүн амын бүтцэд өндөр настай хүмүүс зонхилоход хүргэлээ. Үүний сацуу хөдөлмөрлөх чадвартай хүмүүсийн тоо хөдөлбөргүй багасч байна гэжээ. Хятадын шинжээчдийн хийсэн ийм дүгнэлт олон улсын үнэлгээнд нийцсэн байна.

НҮБ-ын урьдчилан таамагласнаар өнөөгийн байдал хэвээр хадгалагдвал 2050 он гэхэд Хятад улс ажиллах хүчнийхээ барагцаалбал 17 хувийг алдаж мэдэхээр байна гэжээ. Хятадын эрдэмтэд эдийн засгийн хөгжлийн өнөө үед хоёр хүүхэдтэй байхыг бүх гэр бүлд зөвшөөрч болно гэж үзсэн байна. Энэ нь 30 хүрээгүй

хятад хүмүүсийн тэн хагас гаруй нь хоёроос илүү олон хүүхэдтэй болохыг эрмэлзэхгүйг харуулсан санал асуулгын үр дүнд нийцжээ. Иймээс хүн ам зүйн «тэсрэлт» болохгүй. Нөхцөл байдал улс орны өнөөгийн хөгжлийн түвшинд нийцэх юм.

Хүн ам зүйн өнөөгийн бодлогыг цаашид үргэлжлүүлэх нь улс орны эдийн засгийн хөгжлийн ашиг сонирхолд харшилж байна. Учир нь хөдөлмөрийн асар их хэмжээний нөөц Хятад улсын давуу тал ямагт байсан гэж Оросын ШУА-ийн Алс Дорнодын хүрээлэнгийн дэд захирал профессор Сергей Лузянин үзэж байна. Тэрээр хэлэхдээ: «Миний бодоход Хятадын удирдлага одоогоос таван жилийн өмнө шинэтгэл ид явагдаж, эдийн засгийн гайхамшигт үр дүнд хүрсэн үед хүн ам зүйн бодлогод засвар оруулах байсан. Амжилт, ДНБ-ний өсөлт эгэл жирийн хүмүүсийг умартахад хүргэв. Үүний улмаас хүн ам зүйн асуудал эн түрүүнд гарсан» гэж дүгнэжээ. Дээрх асуудалтай холбогдуулан Хятадын дотоодын интернэтийн сүлжээгээр гарч буй тайлбараас үзэхүл, олон нийт хүүхэд төрөлтийн төлөвлөгөөт бодлогыг зөөлрүүлэх арга хэмжээг сайшаан дэмжсэн байна.

ДҮГНЭЛТ

Ийнхүү өнгөрсөн онд хуралдсан ХКН-ын XVIII их хурал нь дэлхий нийтийн анхаарлын төвд байсан нь БНХАУ-ын ойрын 10 жилийн хөгжлийг тодорхойлох, шинэ удирдлагаа сонгосон явдалтай холбоотой байсан юм. Оросын эрдэмтэн судлаачдын үзэл бодол, дүгнэлт, байр суурийг хэвлэл мэдээллийн хэрэгслэлээс сонгон авч дараах дүгнэлтэнд хүрлээ.

Оросын эрдэмтэн судлаачид ХКН-ын XVIII их хурлаар дэвшүүлсэн "Хятадын улс үндэстний их сэргэн мандалт" буюу хятад үндэстэнг сэргээх тухай алхам нь үндсэрхэг хандлага, үндсэрхэг үзэл рүү бага зэрэг хэлбийж байгааг илтгэж байна. Мөн "хятад мөрөөдөл"-ийг нэлээд хийсвэр үзэл санаа гэж олонх шинжээч тэмдэглэж, "хятад мөрөөдөл" гэгчийг хамт олны үнэ цэнэтэй зүйл, нийт үндэстний ашиг сонирхол дээр бий болгох ажээ гэсэн таамаг дэвшүүлсэн юм.

Үүнээс гадна Хятадын эдийн засгийн өнөөгийн хөгжлийг тодорхойлохдоо, дэлхий нийтээрээ Хятадыг эдийн засгийн хөгжлийн зүтгүүр гэж үзэж байна. Хэрвээ БНХАУ-ын эдийн засаг өсвөл хямралын үед бүгдийг нь дэмжих болно. Хүн амынхаа орлогын түвшинг нэмэгдүүлэх нь зөвхөн Хятадын эдийн засгийг ч өсгөөд зогсохгүй бусад улс орнуудад тогтвортой байдлын баталгаа болно гэсэн дүгнэлтэнд хүрчээ. Улмаар цаашид шинэ удирдлага

эдийн засгийн шинэтгэлийг хэрхэн явуулах, валют, санхүүгийн хямралыг зохицуулах, хөрөнгө оруулалтын талаарх асуудлыг хөндөж тавьжээ.

Нөгөөтэйгүүр нийгмийн тогтвортой байдлын асуудалд Хятадын удирдлагууд нэлээд түгшиж байгаа талаар санал бодлоо илэрхийлж, шинэ удирдлагуудын хувьд хямралын үед төр засгаа бэхжүүлэх нь гол зорилт гэдгийг харуулах ёстой гэж дүгнэсэн байна. Өнгөрсөн үед бий болгосон Хятадын эдийн засгийн хөгжлийн загвар нь үеэ өнгөрөөсөн хэмээн зарим шинжээчид үзжээ. Улмаар Оросын эрдэмтэн судлаачид Хятадын шинэ удирдлага авлига хээл хахуультай хэрхэн тэмцэж байгаа, ямар сөрөг үр дагавар дагуулж буй, байгаль экологийн асуудал, хүн ам зүйн өнөөгийн бодлогын талаар тус бүрд нь өөрийн үзэл бодлоо илэрхийлж, дүгнэлт, тайлбар хийснийг багтаасан болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

1. “Жэнминь жибао” 2013.03.03
2. http://news.xinhuanet.com/politics/2013-03/03/c_124408203_2.htm
3. Коллаж: “Голос России”
4. Хятад улсад болж байгаа үйл явдал ба Орос улсын байр суурь (192 материал) <http://mongolian.ruvr/108251553/index.html>.
5. Цзян Фэн. Инновационная политика: международный опыт (Китай) journalistic@rambler.ru
6. <http://chelt.ru/new/?p=1545>
7. <http://www.olloo.mn/modules.php?name=news&file=article&sid=12>
8. <http://www.tsahimurtuu.mn/index.php/component/2/item-list/user/flickr.com/firz/cc-by-nc-sa> 30
9. “Өглөөний сонин” 2013-04-17 /Мэдээний дүн/

Abstract: The paper aims to examine the proceedings, significance, and specialty of the 18th National Congress of the Communist Party of China and the new rulership of ‘the fifth generation’ and the state of socio-economic development of China in the opinion of international, in particular Russian researchers.

Keywords: the Communist Party of China, National Congress, new rulership, political and socio-economic development